**ТӨВ АЙМГИЙН ЖАРГАЛАНТ СУМЫН**
**ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН**
**ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2020 оны 01 сарын 28 өдөр Дугаар 07 Жаргалант

Ойн сангаас 2020 онд мод бэлтгэх
модны хэмжээ, хуваарь батлах тухай

Сумын Засаг дарга Т.Цолмонгэрлийн өргөн барьсан "Ойн сангаас 2020 онд мод бэлтгэх модны хэмжээ, хуваарь"-ийн төслийг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцээд "Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль"-ийн 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалт, "Байгаль орчныг хамгаалах хууль"-ийн 3 дугаар бүлгийн 17 дугаар зүйлийн 17.1.2 дахь заалт, "Ойн тухай хууль"-ийн 3 дугаар бүлгийн 18 дугаар зүйлийн 18.1.2 дахь заалт, 6 дугаар бүлгийн 32 дугаар зүйлийн 32.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн Төв аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 131 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор ТОГТООХ нь:

1. Сумын хэмжээнд иргэд, аж ахуй нэгж, байгууллагын хэрэгцээнд зориулан цэвэрлэгээний огтлолтоор хэрэглээний нарс-100м$^3$, түлшний мод нарс -500м$^3$, улиас,улиангар-600м$^3$, хус-100 м$^3$, цэвэрлэгээний ажлаар хэрэглээний мод нарс-500м$^3$ улиангар-50м$^3$, хус-50м$^3$, цэвэрлэгээний ажлаар түлшний мод нарс-700м$^3$, улиас, улиангар-500м$^3$, хус-200м$^3$, уламжлалт бүтээгдэхүүн хийх зориулалтаар нарс-100м$^3$, улиас, улиангар-50м$^3$, хус-50м$^3$, нийт бэлтгэх модны хэмжээ хэрэглээ 900 м$^3$, түлээ 2600 м$^3$ бүгд 3500 м$^3$-ээр баталсугай.

2. Сумын хэмжээнд "2020 онд ойн сангаас бэлтгэх модны хэмжээ, хуваарь"-ийг 1 дүгээр хавсралтаар, "2020 онд ахуйн болон уламжлалт бүтээгдэхүүн үйлдвэрлэх зориулалтаар багуудад хуваарилсан модны хэмжээ"-г 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Энэхүү тогтоолыг хэрэгжүүлж, дараах арга хэмжээ авч ажиллахыг сумын Засаг дарга /Т.Цолмонгэрэл/-д даалгасугай.

3.1 Батлагдсан хуваарьт орсон цэвэрлэгээний огтлолтоор бэлтгэх мод бэлтгэлийн ажлыг шаардлага хангасан мэргэжлийн байгууллагаар бэлтгүүлэн бэлтгэсэн модны хэмжээгээр ойжуулалт хийлгэх

3.2 Батлагдсан хуваарьт багтаан ойн сангаас мод бэлтгэх зөвшөөрөл олгохдоо тухайн бэлтгэсэн модоор орон нутгийн иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудын хэрэгцээг хангах бодлогыг баримтлан ажиллах

3.3 Ойгоос мод бэлтгэх ажлыг холбогдох заавар, журмын дагуу гүйцэтгүүлж цэвэрлэгээний огтлолт, цэвэрлэгээний ажлаар бэлтгэсэн модны 100 шоо метр тутамд 2.0 га талбайд ойжуулалтын ажлыг холбогдох ойн нөхөрлөлүүд, аж ахуй нэгж байгууллагын өөрийн хөрөнгөөр хийлгэх ажлыг зохион байгуулах.

3.4 Аж ахуй нэгжүүдийн цэвэрлэгээний огтлолтоор бэлтгэсэн модыг орон нутгийн иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын хэрэгцээнд зориулан борлуулах ажлыг зохион байгуулах.

3.5 Монгол улсын Засгийн газрын 2014 оны 30 дугаар тогтоолоор батлагдсан “Ойн цэвэрлэгээ” хөтөлбөрийг хэрэгжүүлж, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны “Ойн цэвэрлэгээгээр бэлтгэх модны тухай” 56 дугаар тогтоолыг удирдлага болгон ойн цэвэрлэгээг тогтоосон журмын дагуу хийлгэх.

4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /П.Ганпүрэв/-д үүрэг болгосугай.

ДАРГА Д.УРАНЧИМЭГ

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн
2020 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн 07 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

# 2020 ОНД ОЙН САНГААС БЭЛТГЭХ МОДНЫ ХЭМЖЭЭ, ХУВААРЬ

| № | Аж ахуйн нэгж, нөхөрлөлийн нэрс | Аж ахуйн нэгж, нөхөрлөлийн, захирал, ахлагчийн нэрс | Эзэмшсэн талбайн хэмжээ /га/ | Бэлтгэх модны хэмжээ / м3/: ААН,Байгууллага иргэд, ойн санг гэрээгээр эзэмшигч нөхөрлөлийн ойн цэвэрлэгээний ажлаар бэлтгэх түлшний модны хэмжээ — Модны төрөл: Нарс | Улиас улиангар | Хус | Ойн санг гэрээгээр эзэмшигч аж ахуй нэгж, иргэдийн нөхөрлөлийн цэвэрлэгээний ажлаар бэлтгэх хэрэглээний модны хэмжээ: Нарс | Улиас улиангар | Хус | Мэргэжилийн байгууллагаар цэвэрлэгээний огтлолтоор бэлтгэх хэрэглээ: Нарс | Мэргэжлийн байгууллагын цэвэрлэгээний огтлолтоор бэлтгэх түлээ: Нарс | Улиас улиангар | Хус | Мод бэлтгэлийн талбай тусгаарлалт /га / -аар | Уламжлалт бүтээгдэхүүн хийх зориулалтаар бэлтгэх: Нарс | Улиас улиангар | Хус |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| А | Б | 01 | 02 | 03 | 04 | 05 | 06 | 07 | 08 | 09 | 10 | 11 | 12 | 13 | 14 | 15 | 16 |
| | ЭНЕРЖИ АКУМЕН ХХК | | | | | | | | | 100 | 500 | 600 | | 24 | | | |
| 1 | Арвин баян жаргалант | Г.Гантулга | -- | - | 20 | - | **30** | **10** | | | | | - | | - | - | - |
| 3 | Буйлааст | А.Сүрэнчимэг | 472 | - | 10 | - | **10** | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| 4 | Ногоон монос | Б.Түмэнжаргал | 1050 | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| 5 | Ногоон гацуур | Л.Болдбаатар | 84 | 10 | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |

| | | | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 6 | Буян арвижих | Р.Баярсайхан | 664 | 10 | 20 | 10 | - | - | - | - | - | - | - | - | - | | |
| 7 | Өвөр марцтай | Ч.Баатар-Эрдэнэ | 525 | 20 | - | 10 | - | - | - | - | - | - | - | | | | **4** |
| 8 | Бугантолгой | Д.Батбаяр | 2611 | 20 | 30 | 10 | **100** | **10** | **10** | | | | | 4 | - | **20** | **20** |
| 9 | Саруул | Л.Нямдорж | 472 | 20 | 10 | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| 10 | Шинэ жаргалант | Г.Батсайхан | 1161 | 20 | 20 | - | **20** | **10** | - | - | - | - | - | 2 | - | - | - |
| 11 | Шинэ төгөл | Э.Мандалбаяр | 91 | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| 12 | Зулзаган төгөл | Г.Нэргүй | 387 | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| 13 | Ногоон нуруу | Т.Доржсүрэн | 648 | 20 | 20 | - | **10** | - | - | - | - | - | - | 2 | - | - | - |
| 14 | Их морин хөтөл | Г.Алтансүх | 625 | 20 | 20 | - | - | - | - | - | - | - | - | 2 | | - | - |
| 15 | Шинэ гацуур | Б.Ганбаатар | 495 | 10 | 10 | - | **20** | - | - | - | - | - | - | 2 | - | - | - |
| 16 | Мухдагийн ой | П.Мөнхсум | 533 | 20 | - | - | **20** | - | **10** | - | - | - | - | 2 | - | - | **20** |
| 17 | Шүтээн хайрхан ганга | Г.Батмөнх | 603 | 20 | 20 | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| 18 | Дэлгэрбулаг | С.Энхбаяр | 648 | 10 | 10 | - | **30** | - | **10** | - | - | - | - | 2 | | - | - |
| 19 | Хонгор баян нуруу | Ю.Ганбаатар | 816 | 20 | - | - | **10** | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| 20 | Ногоон төгөл | Т.Нарантуяа | 372 | - | 10 | - | **10** | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| 21 | Хонгор ээж | Г.Хас-Эрдэнэбаатар | 614 | - | 20 | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| 22 | Хайрхан | Д.Чулуунбаатар | 527 | 10 | 10 | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| 23 | Ар булаг | Б.Батчимэг | 481 | 10 | 10 | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| 24 | Ар цант | Д.Батаа | 375 | 10 | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| 25 | Ногоон ирээдүй | О.Бямбасүрэн | 541 | 30 | 10 | 10 | **50** | - | - | - | - | - | - | 3 | - | - | - |

| | | | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 26 | Буйлааст хайрхан | Д.Цэвэлмаа | 257 | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| 27 | Баян энгэр | Г.Бат-Эрдэнэ | 563 | 30 | 10 | 10 | - | - | - | - | - | - | - | 3 | - | - | - |
| 28 | Хуст | А.Эрдэнэбат | 865 | 30 | 10 | 10 | **50** | **10** | **10** | - | - | - | - | 4 | - | **10** | **6** |
| 29 | Мойл | Ц.Эрхэмбат | 348 | 30 | 10 | 10 | **30** | - | - | - | - | - | - | 4 | - | **10** | - |
| 30 | Цант | О.Батбаяр | 206 | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| 31 | Хөвсгөл Их тайга ХХК | Б.Ганбаатар | 547 | 20 | - | - | - | - | - | - | - | - | - | 3 | **50** | - | - |
| 32 | Өргөн булаг | Ч.Өлзийбадрах | 410 | 10 | 10 | 10 | - | - | - | - | - | - | - | 3 | - | - | - |
| 33 | Буянт хөрш | Ж.Цолмон | 410 | 10 | 10 | 10 | - | - | - | - | - | - | 50 | 2 | **50** | - | - |
| 34 | Хөвч ой | Г.Баярсайхан | 387 | - | - | - | **10** | - | - | | | | | - | - | - | - |
| 35 | Шар агаа | Д.Батдорж | 392 | - | 10 | 10 | - | - | - | - | - | - | 50 | - | - | - | - |
| 36 | Бяцхан булаг | Г.Дондогбазар | 400 | 10 | 10 | 10 | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| 37 | Хар ямаат | З.Дагвадорж | 193 | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| 38 | Шар хөтөл | Д.Батмөнх | 141 | - | 10 | 10 | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| 39 | Устай нуга | Д.Энхбаатар | 460 | - | 20 | 20 | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| 40 | Мөнх ногоон төгөл | Л.Ганбаатар | 423 | 20 | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| 41 | Тайс | Ц.Пилмаа | 637 | - | 10 | 10 | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| 42 | Бүрэгтий хамтлаг | Б.Батбаяр | 477 | - | 20 | 20 | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| 43 | Бугын ой | В.Сүхбаатар | 623 | 20 | - | - | **20** | **10** | **1** | - | - | - | - | 4 | - | **10** | - |
| 44 | Амар Жаргалан | Т.Ганбаатар | 603 | 20 | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| -45 | Гүн булаг | Б.Отгонбаатар | 1057 | 10 | 20 | 10 | **50** | - | - | - | - | - | - | 4 | - | - | - |
| 46 | Хөндлөн | У.Мөнхбат | 677 | 20 | - | - | **10** | - | - | - | - | - | - | 3 | - | - | - |
| 47 | Баянхангай | Д.Оюун | 712 | 30 | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |

| | | | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 48 | Баянбүрд | Д.Эрдэнэсайхан | | 30 | - | - | **20** | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| 49 | Дэлгэрхангай | Ш.Лайбуу | 607 | 30 | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| Бусад | | | | 100 | 100 | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| **ДҮН** | | | 27114 | 700 | 500 | 200 | **500** | **50** | **50** | **100** | 500 | 600 | 100 | *73* | **100** | **50** | **50** |

*******************

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн
2020 оны 01 дүгээр сарын 28-ний өдрийн 07 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

## 2020 ОНД АХУЙН ХЭРЭГЛЭЭНИЙ БОЛОН УЛАМЖЛАЛТ БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭХ ЗОРИУЛАЛТААР БАГУУДАД ХУВААРИЛСАН МОДНЫ ХЭМЖЭЭ

| № | Багийн нэр | Бэлтгэх модны хэмжээ / м3 / | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Ойн санг гэрээгээр эзэмшигч нөхөрлөл, аж ахуй нэгж, иргэдийн цэвэрлэгээний ажлаар бэлтгэх ахуйн хэрэглээний модны хэмжээ | | | Уламжлалт бүтээгдэхүүн хийх зориулалтаар бэлтгэх модны хэмжээ | | | Нийт бэлтгүүлэх модны хэмжээ /м3/ |
| | | Модны төрөл | | | | | | |
| | | нарс | Улиас,улиангар | хус | нарс | Улиас,улиангар | хус | |
| 1 | Буурал 1-р баг | 180 | 18 | 18 | 36 | 18 | 18 | 288 |
| 2 | Өгөөмөр 2-р баг | 170 | 17 | 17 | 34 | 17 | 17 | 272 |
| 3 | Баянбулаг 3-р баг | 90 | 9 | 9 | 18 | 9 | 9 | 144 |
| 4 | Загдал 4-р баг | 60 | 6 | 6 | 12 | 6 | 6 | 96 |
| Дүн: | | **500** | **50** | **50** | **100** | **50** | **50** | **800** |